



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,  
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.05.28 № 02/1009  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тендерийн баримт бичиг  
хянасан тухай**

Танай төвөөс зарласан “Эм, эмнэлгийн хэрэгсэл” БГДЭМТ/20240102003 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичгийн Багц 6-д “Агниста фарм” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

Тендерийн баримт бичгийн Багц 6-д “1.Тариур 10гр, 2. Тариур 1гр, 3. Тариур 20гр, 4. Тариур 3гр, 5. Тариур 50гр люр, 6. Тариур 5гр, 7. Тариур 60гр жаней” тариуруудыг нэг багц болгон оруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрээс худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичигт заана.”, 8.2-т “Энэ хуулийн 8.1-д заасан барааны нэр, төрлийн жагсаалтыг эдийн засаг, хөгжлийн, хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, Засгийн газар батална”, 10 дугаар зүйлийн 10.4-т “Бараа худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулахад энэ хуулийн 8.2-т заасан барааг бусад бараанаас тусад нь багцална” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор баталсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ын 7.2-т “Эмнэлгийн хэрэгсэл, халдвар хамгааллын хувцас хэрэглэл (нэг удаагийн тариур, зүү, дуслын систем, цусны уут, шээсний уут, малгай, амны хаалт, халат, улавч, ороох боох материал гэх мэт)” гэж заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулахдаа Багц 6-д дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой Тариур 10гр, Тариур 1гр, Тариур 20гр, Тариур 3гр, Тариур 5гр зэрэг барааг импортын бараа бүтээгдэхүүнтэй хамт багцалсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн

0002183

тендерийн баримт бичгийн Багц 6-д холбогдох өөрчлөлт оруулан, хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.

ОРОН ТООНЫ ГИШҮҮН



О.БАТМӨНХ